



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/63

Модот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дүгээр зүйлийн 33.1.1 дахь заалтууд, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 24 дүгээр тогтоолын 8 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгагдсан Цэнхэрмандал сум, 4-р баг Баянмод Модот хаягт байрлах, 5001315 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, Дулаан халаалт, газар дээрх дулаан дамжуулах хоолой зориулалттай, 2438 квадрат метр газрыг “Өндөрхаан илч” ХХК (4199278)-т 15-н жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар эзэмших эрхээ хэрэгжүүлж, эзэмшиж авсан газраа хуулийн дагуу кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигчид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэх, газрын ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А. МӨНХОРГИЛ



